



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2023/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2023 .02.17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)  
“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа  
Утас: 89499922 Цахим хаяг: [enkhtuyad@gmail.com](mailto:enkhtuyad@gmail.com)  
Аудитор Б.Баасанбат  
Утас: 96442101 Цахим хаяг: [baasan.bataa@gmail.com](mailto:baasan.bataa@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.16 № 2/25

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн баталснаар БШУ-ны сайдын 2022.05.12-ны А/170 тушаалаар “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал”-ыг баталсан байна.

Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

005020175

D/2023-A4 Alban toot doc

## **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92%-ийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,626,745.48</b>	<b>54,828,584.48</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	3,857,689.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	3,857,689.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	3,857,689.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,857,689.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	325,000.00	325,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	325,000.00	325,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	325,000.00	325,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,301,745.48	50,645,895.48
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	18,567,030.00	18,567,030.00
35110	Тусгай зориулалттай материал	18,567,030.00	18,567,030.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,734,715.48	32,078,865.48
35410	Бичиг хэргийн материал	381,400.00	513,400.00
35420	Аж ахуйн материал	4,147,000.00	2,180,000.00
35460	Хүнсний материал	838,700.00	273,550.00
35470	Бусад хангамжийн материал	20,367,615.48	29,111,915.48
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>371,521,331.46</b>	<b>358,896,574.94</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	371,521,331.46	358,896,574.94
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	363,019,331.46	350,394,574.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	325,961,789.00	325,961,789.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,360,664.76	-20,040,192.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,719,395.00	44,266,995.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,779,024.17	-26,801,349.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,937,432.04	26,937,432.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,451,526.61	-20,972,371.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,933,996.00	37,933,996.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,187,065.04	-17,136,724.04
39217	Ном	245,000.00	245,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,502,000.00	8,502,000.00
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-225,000.00	-225,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,502,000.00	8,502,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>416,148,076.94</b>	<b>413,725,159.42</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>645,578.71</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>645,578.71</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>645,578.71</b>

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	645,578.71
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>416,148,076.94</b>	<b>413,079,580.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>416,148,076.94</b>	<b>413,079,580.71</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,439,622.35	164,439,622.35
51101	Өмч: - төрийн	164,439,622.35	164,439,622.35
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>67,276,550.76</b>	<b>64,208,054.53</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	67,276,550.76	67,276,550.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-3,068,496.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,431,903.83	184,431,903.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>416,148,076.94</b>	<b>413,725,159.42</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

СТ-2А

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>307,914,398.00</b>	<b>355,163,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,371,972.00</b>	<b>12,047,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>17,371,972.00</b>	<b>12,047,600.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,281,972.00	12,047,600.00
1200009	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүү/х	00.00	7,500,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	4,547,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>32,766,026.00</b>	<b>343,115,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>00.00</b>	<b>290,901,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	290,901,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	257,776,400.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,609,390.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,609,390.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>27,156,636.00</b>	<b>52,213,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,156,636.00	52,213,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>297,111,176.40</b>	<b>358,231,596.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>297,111,176.40</b>	<b>358,231,596.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>278,532,175.95</b>	<b>357,372,198.23</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,954,491.55	226,778,191.00

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210101	Үндсэн цалин	148,341,259.11	161,912,044.00
210102	Нэмэгдэл	18,288,846.00	44,392,097.00
210104	Урамшуулал	23,324,386.44	7,160,242.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	13,313,808.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,720,839.00</b>	<b>28,997,278.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,720,839.00	28,997,278.71
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,166,636.00</b>	<b>31,036,202.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,235,318.00	4,143,782.00
210302	Түлш, халаалт	25,631,318.00	26,592,420.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,403,500.00</b>	<b>5,476,270.00</b>
210401	Бичиг хэрэг	231,900.00	309,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	315,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,381,800.00	958,320.00
210404	Ном, хэвлэл	43,500.00	12,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,946,300.00	3,881,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,853,200.00</b>	<b>41,827,050.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	743,600.00	00.00
210502	Хоол, хүнс	10,706,300.00	41,827,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	403,300.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,364,300.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,364,300.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,069,300.00</b>	<b>644,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	479,300.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	450,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	194,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,999,909.40</b>	<b>21,112,506.52</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,061,000.00	1,391,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,500.00	2,549,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,314,409.40	17,172,356.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,579,000.45</b>	<b>859,398.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,696,390.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,609,390.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	87,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>859,398.00</b>

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	859,398.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,882,610.45	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,882,610.45	00.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,803,221.60</b>	<b>-3,068,496.23</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,803,221.60</b>	<b>-3,068,496.23</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>290,542,426.00</b>	<b>350,615,500.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>7,500,000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	7,500,000.00
1200009	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,500,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>290,542,426.00</b>	<b>343,115,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	290,901,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	290,901,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	257,776,400.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,609,390.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,609,390.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,156,636.00	52,213,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,156,636.00	52,213,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>285,297,426.00</b>	<b>346,757,811.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>285,297,426.00</b>	<b>346,757,811.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>266,718,425.55</b>	<b>345,898,413.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,057,589.55	226,778,191.00
210101	Үндсэн цалин	143,407,413.11	161,912,044.00
210102	Нэмэгдэл	18,288,837.00	44,392,097.00
210104	Урамшуулал	25,361,339.44	7,160,242.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	13,313,808.00
2102	Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,811,300.00	28,351,700.00

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	19,726,400.00	19,411,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,031,800.00	2,235,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,583,400.00	1,788,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	406,400.00	447,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,063,300.00	4,470,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,656,636.00</b>	<b>31,036,202.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,235,318.00	3,638,471.00
210302	Түлш, халаалт	25,121,318.00	27,122,731.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	275,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,822,900.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	178,300.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,381,800.00	00.00
210404	Ном, хэвлэл	43,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,419,300.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,575,900.00</b>	<b>41,261,900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	640,600.00	00.00
210502	Хоол, хүнс	11,545,000.00	41,261,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	390,300.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,364,300.00</b>	<b>1,500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,364,300.00	1,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,147,300.00</b>	<b>590,620.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,300.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	590,620.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,282,500.00</b>	<b>16,379,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,000.00	13,619,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	732,500.00	2,760,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,579,000.45</b>	<b>859,398.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,696,390.00</b>	<b>00.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,609,390.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	87,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>859,398.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	859,398.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,882,610.45</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,882,610.45	00.00

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,245,000.00</u>	<u>3,857,689.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,245,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,245,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,245,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,245,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,245,000.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,857,689.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,857,689.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,439,622.35	184,431,903.83	67,276,550.76	416,148,076.94
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	164,439,622.35	184,431,903.83	67,276,550.76	416,148,076.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,439,622.35	184,431,903.83	67,276,550.76	416,148,076.94
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,068,496.23	-3,068,496.23
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,439,622.35	184,431,903.83	64,208,054.53	413,079,580.71

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Өөрчлөлт	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	350,615,500.00	345,898,413.00	-4,717,087.00	98.65
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	350,615,500.00	345,898,413.00	-4,717,087.00	98.65
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	350,615,500.00	345,898,413.00	-4,717,087.00	98.65
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	226,807,300.00	226,778,191.00	-29,109.00	99.99
210101	Үндсэн цалин	170,921,000.00	161,912,044.00	-9,008,956.00	94.73
210102	Нэмэгдэл	33,728,500.00	44,392,097.00	10,663,597.00	131.62
210104	Урамшуулал	5,431,400.00	7,160,242.00	1,728,842.00	131.83
210105	Гэрээт ажлын хөлс	16,726,400.00	13,313,808.00	-3,412,592.00	79.60
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,351,700.00	28,351,700.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,399,400.00	19,411,300.00	11,900.00	100.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,238,100.00	2,235,200.00	-2,900.00	99.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,790,400.00	1,788,200.00	-2,200.00	99.88
210204	Ажилгүйдлийн даатгал	447,700.00	447,000.00	-700.00	99.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,476,100.00	4,470,000.00	-6,100.00	99.86
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,895,600.00	31,036,202.00	-859,398.00	97.31
210301	Гэрэл, цахилгаан	4,437,400.00	3,638,471.00	-798,929.00	82.00
210302	Түлш, халаалт	27,158,200.00	27,122,731.00	-35,469.00	99.87
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	275,000.00	-25,000.00	91.67
2105	<b>Нормативт зардал</b>	44,769,100.00	41,261,900.00	-3,507,200.00	92.17
210502	Хоол, хүнс	44,769,100.00	41,261,900.00	-3,507,200.00	92.17
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	592,000.00	590,620.00	-1,380.00	99.77
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	590,620.00	-1,380.00	99.77
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16699800.00	16379800.00	-320,000.00	98.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,939,800.00	13,619,800.00	-320,000.00	97.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,760,000.00	2,760,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	350,615,500.00	349,756,102.00	-859,398.00	99.75
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	290,901,900.00	290,901,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	290,901,900.00	290,901,900.00	0.00	100.00

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	52,213,600.00	51,354,202.00	-859,398.00	98.35
132001	Орон нутгийн төсвөөс	52,213,600.00	51,354,202.00	-859,398.00	98.35
1E+05	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16.00	16.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00	100.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	92.00	92.00	0.00	100.00
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	92.00	92.00	0.00	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	92.00	92.00	0.00	100.00
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	92.00	92.00	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	92.00	92.00	0.00	100.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянбулаг сумын Цэцэрлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж зорилго зорилтыг тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Засгийн газрын 2021.12.21-ны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсан
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУ-ны сайдын 2022 оны “Заавар батлах тухай “ А/170 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал “
- БШУ-ны сайд, ЭМС-ын 2022 оны А/235, А/340 дугаар хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай тушаал

- Мөн Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 107, 192 дугаар тогтоолууд
- БШУ-ны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам,
- БШУ-ны сайдын 2022 оны А/500 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох журам

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Харин Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д зааснаар Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг БШУЯ-ны Боловсролын ерөнхий газарт нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 413,725.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 2,243.0 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	44,626.7	54,828.6	10,201.8
Мөнгөн хөрөнгө	-	3,857.7	3,857.7
Авлага	-	-	-
Урьдчилгаа	325.0	325.0	-
Бараа материал	44,301.7	50,645.9	6,344.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	371,521.3	358,896.6	(12,624.8)
Үндсэн хөрөнгө	439,524.6	444,072.2	4,547.6
Хуримтлагдсан элэгдэл	(68,003.3)	(85,175.6)	(17,172.4)
<b>Нийт хөрөнгө</b>	416,148.1	413,725.2	(2,422.9)
Өр төлбөр	-	645.6	645.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	416,148.1	413,079.6	(3,068.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	416,148.1	413,725.2	(2,422.9)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн данс нь 3,857.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансанд оны эхэнд байсан 325.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа тул дараагийн аудитаар анхаарах асуудалд бичсэн болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,645.9 мянган төгрөг болж 6,344.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 56,490.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 50,146.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 50,645.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарснаас бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 8,744.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 444,072.2 мянган төгрөг болж 4,547.6 мянган төгрөгөөр өссөн нь БШУ-ны сайдын 2022.11.23-ны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ын хүрээнд Боловсролын ерөнхий газраас 2 ш зөөврийн компьютер нийлүүлэгдсэн байна.

Тайлант онд 645.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын дагуу дутуу

мэдээлсэн цалингийн санг нөхөн мэдээлэх залруулгыг НДХ оны эцсээр гүйлгээ хаагдсанаас хойш хийсэнтэй холбоотой өр үүсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 413,079.1 мянган төгрөг болж 3,069.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 504,488.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 152,235.3 мянган, норматив зардлыг 42,443.5 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,165.8 мянган, урсгал шилжүүлгийн зардлыг 19,221.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 284,947.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 350,615.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 290,901.9 мянган төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлогоос 7,500.0 мянган төгрөгийн, тогтмол зардлын санхүүжилтэд 52,213.6 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар төсвийг хуваарилжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 2 удаа тодотгосон байна.

Гүйцэтгэлээр батлагдсан төсвийг бүрэн санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345,898.4 төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 859.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 3,857.7 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71801- Сургуулийн өмнөх боловсрол	350,615.5	345,898.4	4,717.1	98.7

**Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	52,213.6	51,354.2	859.4	98.3
АРГА ХЭМЖЭЭ 81605- Эрүүл мэндийг дэмжих	800.0	480.0	320.0	60.0
АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	44,769.1	41,269.1	3,507.2	92.2
АРГА ХЭМЖЭЭ 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,143.8	1,143.8	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81823- Боловсролын байгууллагын багш,	800.0	800.0	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт, сургалт	202,730.3	202,049.4	1,680.9	99.7
АРГА ХЭМЖЭЭ 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	40,658.7	42,309.2	-1,650.4	100
АРГА ХЭМЖЭЭ 83601- Нэмэлт-бараа үйлчилгээний бусад зардал	7,500.0	7,500.0	0.0	100

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Б.Баасанбат нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Баянбулаг сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 57 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 326,903.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,903.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 3,677.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийн хүрээнд 350,615.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс нийт 4,717.1 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 859.4 мянган төгрөг
- Бараа , үйлчилгээний бусад зардлаас 320.0 мянган төгрөг
- Хүүхдийн хоолны зардлыг 3,507.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагааны 44,769.1 мянган төгрөгийн 1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 285,043.4 мянган төгрөгийн 22 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 31,449.2 мянган төгрөгийн 5 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 6,069.2 мянган төгрөгийн 3 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийссэн ба завсрын аудитаар зөрчил, дутагдал илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар нийт 64,763.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлэн биелэлтийг 2022.06.02-ны өдрийн 11 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Мөн 10 ажилтны 2,488.5 мянган төгрөгийн цалингийн санг НДХ-т дутуу мэдээлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	52,275.3	1	52,275.3	100
Албан шаардлага	1	2,488.5	1	2,488.5	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>64,763.8</b>	<b>2</b>	<b>64,763.8</b>	<b>100</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 онд хоолны зардал 3507,2 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй , харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---